Тайлант онд нийт нэмэгдсэн 195,897.6 мянган төгрөгийн бараа материалаас 60,654.7 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр, 1,700.3 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар, 133,542.6 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Мөн нийт хасагдсан 166,421.0 мянган төгрөгийн бараа материалаас 154,286.3 мянган төгрөгийг зарцуулж, 12,134.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

Хүснэгт № 7. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	195,897.6	Хасагдсан	166,421.0
Худалдан авсан	60,654.7	Худалдсан, зарцуулсан	154,286.3
Хандиваар	1,700.3	шилжүүлсэн	12,134.7
Шилжүүлсэн авсан	133,542.6		

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,843,373.6 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 4,021,001.8 мянган төгрөг болж 177,628.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	3,792,175.0	3,971,377.2	179,202.2	98.8
Барилга байгууламж, орон сууц	2,872,267.3	3,020,471.3	148,204.0	75.1
Тээврийн хэрэгсэл	305,464.8	249,532.3	-55,932.5	6.2
Машин тоног төхөөрөмж	321,262.8	427,976.4	106,713.6	10.6
Тавилга эд хогшил	104,545.0	84,762.1	-19,782.9	2.1
Номын фонд	24,508.6	24,508.6	0.0	0.6
Бусад үндсэн хөрөнгө	164,126.5	164,126.5	0.0	4.1
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	51,198.6	49,624.6	-1,574.0	1.2
Программ хангамж	1,075.0	1,075.0	0.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	50,123.6	48,549.6	-1,574.0	1.2
НИЙТ ДҮН	3,843,373.6	4,021,001.8	177,628.2	100.0

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 99.2 хувь ЗДТГ, 0.8 хувь нь ИТХ-ийн хөрөнгө байна.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	28,839.1	32,216.1	3,377.0	0.8
ЗДТГ	3,814,534.4	3,988,785.7	174,251.3	99.2
НИЙТ ДҮН	3,843,373.5	4,021,001.8	177,628.3	100.0

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө 24,858.0 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн нь ЗДТГ нь төсвийн хөрөнгөөр 24,858.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймгийн ИТХ-ын даргын 2024.04.03-ны өдрийн “Үндсэн хөрөнгөнд эзэмшигч тогтоох тухай” 25 дугаар захирамж, 2024.06.26-ны өдрийн 56 дугаар захирамж, 2024.11.18-ны 99 дүгээр захирамжаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 46,865.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг ЗДТГ-т, 3,377.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг ИТХ-д бүртгэсэн, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 200,497.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Мөн аймгийн ИТХ-ын даргын 2024.05.30-ны өдрийн “Хөрөнгө акталж данснаас хасах тухай” 38 дугаар захирамжаар сумын ЗДТГ-ын 76,405.8 мянга, 2024.05.30-ны өдрийн 40 дүгээр захирамжаар 19,990.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар захирамжаар дуудлага худалдаагаар зарагдсан барилгын газрын шилжүүлээгүй байсан сумын ЗДТГ-ын 1,574.0 мянган төгрөгийн газрыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 10. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	275,598.1	Хасагдсан	97,969.8
Худалдан авсан	24,858.0	Шилжүүлсэн	1,574.0
Хандиваар авсан	250,740.1	Акталсан	96,395.8

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5,994.0 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 281,632.3 мянган төгрөг болж 275,638.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	5,994.0	281,632.3	275,638.3	100.0
Байгууллагад төлөх өглөг	5,994.0	184,791.7	178,797.7	65.6
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	-	96,840.6	96,840.6	34.4
Дүн	5,994.0	281,632.3	275,638.3	100.0

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 281,632.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЗДТГ 885.9 мянга, ИТХ 548.0 мянга, ОНХС 96,840.6 мянга, орон нутгийн ерөнхий орлого 96,840.6 мянган төгрөгийн үлдэгдэл өр байна.

Хүснэгт № 12. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ		548.0	548.0	0.2
ЗДТГ	5,994.0	885.9	(5,108.1)	0.3
ОНХС		183,357.8	183,357.8	65.1
Орон нутгийн ерөнхий орлого		96,840.6	96,840.6	34.4
ДҮН	5,994.0	281,632.3	275,638.3	100.0

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,078,677.4 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 4,021,836.50 мянган төгрөг болж, 56,840.9 мянган төгрөгөөр төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 13. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВИЙ ОРОЛЦОО /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	705,282.6	705,282.6	-	17.5



Өмч: - төрийн			-	-
Хуримтлагдсан үр дүн	3,269,027.4	3,222,175.4	(46,852.0)	80.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	104,367.4	94,378.5	(9,988.9)	2.3
Дүн	4,078,677.4	4,021,836.50	(56,840.9)	100.0

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 56,840.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/91 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 374,375.0 мянга, хүү торгуулийн орлогыг 6,000.0 мянга, нийт 380,375.0 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 24/22 дугаар тогтоолоор 103,800.0 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №14. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	2,646,584.1	587,614.2	2,058,969.9	22.2
Татварын орлого	478,175.0	581,506.2	(103,331.2)	121.6
Орлогын албан татвар	385,100.0	475,403.1	(90,303.1)	123.4
ХХОАТ	385,100.0	475,403.1	(90,303.1)	123.4
ЦХТА рлого /суутган/	227,000.0	261,694.2	(34,694.2)	115.3
Үйл ажиллагааны орлого	102,700.0	151,631.0	(48,931.0)	147.6
Хөрөнгийн орлого	52,400.0	57,727.0	(5,327.0)	110.2
Хөрөнгө борлуулсны орлого	3,000.0	4,350.9	(1,350.9)	145.0
Хөрөнгийн албан татвар	80,315.0	95,708.7	(15,393.7)	119.2
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	4,600.0	6,416.7	(1,816.7)	139.5
Галт зэвсгийн албан татвар	2,715.0	2,820.0	(105.0)	103.9
Малд ногдуулах албан татвар	73,000.0	86,472.0	(13,472.0)	118.5
Бусад татвар, төлбөр, хураамж	11,160.0	6,466.2	4,693.8	57.9
Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,160.0	6,466.2	4,693.8	57.9
Улсын тэмдэгтийн хураамж	1,000.0	531.2	468.8	53.1
ТТАМАТөлбөр	500.0	500.0	-	100.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9,660.0	5,435.0	4,225.0	56.3
Газрын төлбөр	1,600.0	3,928.2	(2,328.2)	245.5
Газрын төлбөр	1,600.0	2,101.0	(501.0)	131.3
Газрын дуудлага худалдааны орлого		1,827.2	(1,827.2)	
Татварын бус орлого	2,168,409.1	1,447,957.3	720,451.8	66.8
Нийтлэг татварын бус орлого	683,440.0	46,816.0	636,624.0	6.9
Торгуулийн орлого	6,000.0	6,108.0	(108.0)	101.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого	77,440.0	40,708.0	36,732.0	52.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,440.0	36,944.5	39,495.5	48.3

Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.0	3,763.5	(2,763.5)	376.4
Тусламжийн орлого /гадаад/	600,000.0		600,000.0	
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,484,969.1	1,401,141.3	83,827.8	94.4
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,484,969.1	1,401,141.3	83,827.8	94.4

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 121.6 хувь буюу 103,331.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 34,694.2 мянга, үйл ажиллагааны орлого 48,931.0 мянга, хөрөнгийн орлого 5,327.0 мянга, хөрөнгө борлуулсны орлого 1,350.9 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 1,816.7 мянга, галт зэвсгийн албан татвар 105.0 мянга, малд ногдох албан татвар 13,472.0 мянга, газрын төлбөрийн орлогыг 501.0 мянга, газрын дуудлага худалдааны орлогыг 1,827.2 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин улсын тэмдэгтийн хураамжийг 468.8 мянга, хог хаягдлын хураамж 4,225.0 мянган төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

Хүү, торгуулийн орлогоор 6,000.0 мянган төгрөгөөр оруулахаар төлөвлөж 6,108.0 мянган төгрөгийн орлого оруулж 108.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1,000.0 мянган төгрөгийн орлогыг оруулахаар төлөвлөж 1,763.5 мянган төгрөгийн орлого оруулж 763.5 мянган төгрөгөөр давуулсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 76,440.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 36,911.5 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн өвс, тэжээлийн орлогоос 2,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 73,402, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 4,006,068.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж 2,950,416.5 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,432,659.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 1,517,756.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл /мянган төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Нийт зарлага ба зээлийн дүн	4,006,068.0	2,950,416.5	1,055,651.5	73.6
70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	169,109.3	157,726.8	11,382.5	93.3
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	167,109.3	156,404.8	10,704.5	93.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	2,000.0	1,322.0	678.0	66.1
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	1,034,839.0	989,575.2	45,263.8	95.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	737,717.3	721,440.9	16,276.4	97.8
80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	137,585.9	133,901.7	3,684.2	97.3
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,000.0	800.0	200.0	80.0

81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	73,320.0	54,515.2	18,804.8	74.4
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	75,555.8	69,334.8	6,221.0	91.8
82212 хур хог хаягдал, орчны бохирдол	9,660.0	9,582.6	77.4	99.2
70503 Орон нутгийн зорилтот орон оруулалт	2,415,313.6	1,517,756.5	897,557.1	255.7
80904 Нийгмийн зориулалттай барилга	257,344.5	248,444.5	8,900.0	96.5
83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	1,211,691.1	930,815.0	280,876.1	76.8
73402 ОНХС-хайгуулийн тусгай зөвшөөрлийн төлбөр	2,468.0	0.0	2,468.0	0.0
73403 ОНХС-ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	139,834.0	0.0	139,834.0	0.0
83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	73,000.0	29,181.6	43,818.4	40.0
83406 ОНХС -бусад	730,976.0	309,315.4	421,660.6	42.3
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	38,761.9	37,045.2	1,716.7	95.6
80112 Нийтлэг үйлчилгээ	38,761.9	37,045.2	1,716.7	95.6
71702 Соёл урлаг	26,269.8	24,764.8	1,505.0	94.3
80112 Нийтлэг үйлчилгээ	26,269.8	24,764.8	1,505.0	94.3
71801 Сургуулийн өмнөх боловсрол	56,225.0	55,579.1	645.9	98.9
80112 Нийтлэг үйлчилгээ	56,225.0	55,579.1	645.9	98.9
71802 Ерөнхий боловсрол	167,830.4	167,818.9	11.5	100.0
80112 Нийтлэг үйлчилгээ	167,830.4	167,818.9	11.5	100.0
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	97,719.0	150.0	97,569.0	0.2
82611 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	97,719.0	150.0	28,935.6	84.2

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар 18/91 дүгээр тогтоолоор нийт 3,828,520.3 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 24/22 дугаар тогтоолоор 177,547.7 мянган төгрөгийг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №16. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	155,417.4	165,061.5	-9,644.1
Засаг даргын Тамгын газар	855,820.9	964,839.1	-109,018.2
Сургууль	172,135.5	167,030.4	5,105.1
Цэцэрлэг	54,517.5	55,225.0	-707.5
Эрүүл мэндийн төв	38,432.6	38,761.9	-329.3
Соёлын төв	54,580.0	26,269.8	28,310.2
Сум хөгжүүлэх сан		97,719.0	-97,719.0
Орон нутгийн хөгжлийн сан		2,313,613.6	-2,313,613.6
Нийт дүн	1,330,903.9	3,828,520.3	-2,497,616.4

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар 18/91 дүгээр тогтоолоор нийт 3,828,520.3 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 24/22 дугаар тогтоолоор 177,547.7 мянган төгрөгөөр өсгөж 4,006,068.0 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1,484,969.1 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 818,130.3 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 484,175.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 6,000.0 мянган төгрөгийг хүү, торгуулийн орлогоос, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос, 76,440.0 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлогоос, 600,000.0 мянган төгрөгийн хандив тусламжийн орлогоос, 278,623.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 818,130.3 мянга, орон нутгийн орлогоос 746,905.1 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 1,401,141.3 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1,763.5 мянга, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 36,911.5 мянга, ОНХС-ийн малжуулахын авлага 2,000.0 мянга, хандив тусламжийн орлогоос 300,000.0 мянга нийт 3,245,562.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн 61,289.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №17. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН
ЗДТГ	1,034,839.0	989,575.1	45,263.9	95.6	46,027.5
ИТХ	169,109.3	157,726.8	11,382.5	93.3	11,382.5
Соёлын төв	26,269.8	24,764.8	1,505.0	94.3	1,505.0
Сум хөгжүүлэх сан	97,719.0	150.0	97,569.0	0.2	
Сургууль	167,830.4	167,818.9	11.5	100.0	11.5
Цэцэрлэг	56,225.0	55,579.1	645.9	98.9	645.9
ЭМТ	38,761.9	37,045.2	1,716.7	95.6	1,716.7
ОНХС	2,415,313.6	1,517,756.5	897,557.1	62.8	
Нийт дүн	4,006,068.0	2,950,416.4	1,055,651.6	73.6	61,289.1

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,950,416.4 мянган төгрөг буюу 73.6 хувьтай байгаа нь урсгал зардлыг ЗДТГ-ын 46,027.5 мянга, ИТХ-ын 11,382.5 мянга, тогтмол зардлыг соёлын төв 1,505.0 мянга, бага сургууль 11.5 мянга, цэцэрлэг 645.9 мянга, эрүүл мэндийн төвийн 1,716.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.9.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 11,501.3 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 135,842.8 мянга нийт 147,344.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 11,780.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 3,488.0 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 35,234.9 мянган төгрөгийг тус тус зарцуулж 96,840.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 18. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	11,501.3	135,842.8	147,344.1
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,501.3		11,501.3
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		135,842.8	135,842.8
НИЙТ ЗАРЛАГА	10,466.3	40,037.3	50,503.6
Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.0	2,488.0	3,488.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		11,780.7	11,780.7
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,466.3	25,768.6	35,234.9
Төсөвт төвлөрүүлсэн	1,035.0	95,805.5	96,840.5

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж аудитын менежер М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 1/132 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Баян-Өндөр сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Б.Далай, 2 дугаар гарын үсгийг санхүү албаны дарга Г.Дүүрэнбилэг нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны нийт батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 65 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 4,006,068.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 60,091.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 39,059.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	13	13	8	2	3
2	Хагас жил	1	1	1		
3	Сар бүр	6	72	68	4	

4	Тухай бүр	5	59	59		
	Нийт	24	145	136	6	3

4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Баян-Өндөр сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 75,555.8 төгрөгөөр баталж 69,334.8 мянган төгрөгийг зарцуулж 6,221.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөтэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баян-Өндөр сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 91.3 хувьтай дүгнэсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 4,006,068.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,950,416.4 мянган төгрөгийг зарцуулж 73.6 хувийн биелэлттэй байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Баян-Өндөр сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №20. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Гүйцэтгэсэн		Гүйцэтгэсэн		Үүнээс				
	Хамрагдвал зохиx	Хамрагдсан	Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс тагталзсан
ЗДТГ	1	1		1					
ИТХурал	1	1		1					
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
НИЙТ ДҮН	4	4		4	0	0	0	0	0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл



Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 214,455.8 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс 4,054.3 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 36,387.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 167,514.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, шилэн дансны хууль зөрчсөнтэй холбоотой 21,861.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, хариуцлага тооцох 1 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргахгүй байх 6,500.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №21. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ЗДТГ	2	6,649.3	1	4,054.3			1	2,595.0		
ОНХСан	2	7,457.0			1	957.0			1	6,500.0
СХС	2	178,488.2			1	35,430.0	1	143,058.2		
СТА зөрчлийн дүн	6	192,594.5	-	-	2	36,387.0	2	145,653.2	1	6,500.0
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЗДТГ	1	21,861.3					1	21,861.3		
ОНХС	1	0					1	0		
Нийцлийн аудитын дүн	2	21,861.3	0	0	0	0	2	21,861.3	0	0
Нийт дүн	8	214,455.8	0	-	2	36,387.0	4	167,514.5	1	6,500.0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 188,540.2 мянган төгрөгийн 5 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 21,861.3 мянган төгрөгийн 2 зөрчил тус тус илэрсэн байна.

Хүснэгт 22. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

8	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
Засаг даргын Тамгын газар		24,456.3			
1	Урьд онд өглөг үүсээгүй байхад 2021 онд үйлдвэрлэсэн өрхийн дэвтрийн үнэ 2,595.0 мянган төгрөгийг Дурсамж принт ХХК-ийн дансруу шилжүүлсэн байна.	2,595.0	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр, Л.Энхбилэг
2	Байгууллагын шилэн дансаны нэгдсэн цахим хуудаст тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 21,861.3 мянган төгрөгийн 3 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.	21,861.3	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр, Л.Энхбилэг
Хоршоо хөгжүүлэх сан		178,488.2			
1	Энх мэнд саруул ХХК нь 2021 оны 03 дугаар сарын 10-нд 40,000.0 мянган төгрөгийн зээлийг сумын "Халуун ус" байгуулах төслийн зориулалтаар 3 жилийн хугацаатай зээл авсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар 35,430.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй байна.	35,430.0	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Далай Г.Бадмаа

**Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2	Тайлант оны эцэст санхүүгийн тайланд 143,058.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байгаа бөгөөд тухайн байгууллагаас ирүүлсэн Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн эргэн төлөлт, үлдэгдлийн дэлгэрэнгүй бүртгэл судалгаатай таарахгүй байна.	143,058.2	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Далай Г.Бадмаа
Орон нутгийн хөгжлийн сан		7,457.0			
1	Сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжсэн "цэцэрлэгийн дулааны шугам сүлжээ шинэчлэх"-ын ажлыг "Буянт хөрс наран" ХХК-тай 2024.08.19-ны өдөр 104,008.2 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан ба ажлыг хүлээн аван зураг төсөв, хяналтын зардлыг шилжүүлэхдээ 957.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн байна.	957.0	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Далай Г.Бадмаа
2	Сумын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан "Малчдад зориулсан сургалт сурталчилгаа" ажлын хүрээнд иргэн Д.Болдбаатартай "Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэх" гэрээг 2024.03.04-нд 15 сая төгрөгөөр байгуулж 6,500.0 мянган төгрөг олгосон ба гэрээний ажлын даалгавар болон гэрээний биелэлтийн тайланд иргэдэд сургалт зохион байгуулаагүй сумын ЗДТГ-ын албан хаагчид ОНХС-ийн нягтлан болон холбогдох төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна.	6,500.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Далай Г.Бадмаа
3	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,774.1 сая төгрөгийн 11, зарлагын 1,468.8 сая төгрөгийн 53 гүйлгээг огт мэдээлэлгүй, тендерийн тайлан байршуулаагүй орхигдуулсан байгаа бөгөөд тус зөрчил нь өмнөх жилийн аудитаар илэрч албан шаардлага хүргүүлсэн боловч 2024 онд зөрчлийг давтан гаргасан байна.	-	Хариуцлага тооцох албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Далай Г.Бадмаа
Нийт дүн		210,401.5			

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,800.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Бараа материалын тайланд сумын ИТХ-ын 5,000.0 мянган төгрөгийн шатахуун, 800,0 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байхад хандиваар гэж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т."үнэн зөв байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт зөрчлийг 1 албан шаардлагыг хүргүүлсэн ба нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 39,059.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитаар 1 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлээ.

2.2 Албан шаардлага

2.2.1. Баян-Өндөр сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас нийт 210,401.5 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс 957.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 59,886.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 149,558.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа төсвийн байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, төсвийн сахилга, бат, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж өөрийн эрхлэх асуудлын хүрээний дотоод хяналтыг хэрэгжүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд орлогыг нэмэгдүүлэн тусгасан	1	5,800.0	-	-	1	5,800.0	1	5,800.0	-	-
Дүн	1	5,800.0	-	-	1	5,800.0	1	5,800.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баян-Өндөр сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас нийт 210,401.5 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс 957.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 59,886.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 149,558.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн байна.	1	0	-	-	1	0	-	-
Дүн	1	0	-	-	1	0	-	-

-----oOo-----